


1. Байрзүйн зургийн шугаман дүрслэлийн аргыг аль нь илэрхийлэх вэ?



2. Мэлхийн зам дээр нар 90^0 өнцгөөр тусах үед манай орны хувьд ямар улирал тохиох вэ?

- A. хавар B. зун C. намар D. өвөл

3. Хүн амын соёлын үзүүлэлтийг тодорхойлоход аль хүчин зүйл хамааралтай вэ?

- A. хөдөлмөр эрхлэлтийн байдал B. хүрээлэн буй орчны байдал
C. иргэдийн эрүүл мэндийн байдал D. бичиг үсэг тайлагдсан байдал

4. Дархан хот нь улсын зэрэглэлтэй хотод хамаарах бөгөөд 2025 оны байдлаар 105122 хүн ам тоологдсон байна. Хүн амын тоогоор дэлхийн хотуудын аль ангилалд хамаарах вэ?

- A. бага хот B. дунд хот C. том хот D. саятан хот

5. Стратегийн орд газрыг илэрхийлэх гол үзүүлэлтийг сонгоорой.

- A. түгээмэл тархацтай нутагт дэвсгэртэй B. улс орны эдийн засгийн хөгжилд нөлөөтэй
C. уур амьсгалын таатай нөхцөлтэй D. судалгаа явуулах хүний нөөц ихтэй

6. Газрын нэгдмэл сангийн суурин газрын ангилалд аль нь хамаарах вэ?

- A. бэлчээрийн газар B. хадлангийн газар
C. үйлдвэрийн газар D. тариалангийн газар

7. Алс зайг богино хугацаанд туулах хэдий ч үнэ өртөг их тээврийн төрлийг хэд дугаараар тэмдэглэсэн байна вэ?



- A. 1 B. 2 C. 3 D. 4

8. Үйлчилгээний салбарыг илэрхийлэх онцлог үйл ажиллагаа аль нь вэ?

- A. Мэдээллийг дамжуулж, түгээдэг. B. Түүхий эдийн олборлолт хийдэг.
C. Хэрэглэгчидтэй шууд харилцдаг. D. Материал үйлдвэрлэл явуулдаг.

9. Монгол орны хамгийн хүйтэн цэг $X\Theta48^{\circ}45',3Y98^{\circ}16'$ -ын солбицолд орших Завхан аймгийн Тосонцэнгэл сум юм. Ихэнхдээ өвөлдөө -40°C хүйтэн байдаг ба хамгийн хүйтэн нь -53°C хүртэл хүйтэрдэг бол энэ үед нарны тусгалын өндөр хэдэн градусын өнцгөөр тусдагийг тооцоолсон хувилбарыг сонгоорой. ($H=90^{\circ}-\varphi\pm23^{\circ}26'$)

- A. $75^{\circ}49'$ B. $64^{\circ}52'$ C. $17^{\circ}49'$ D. $18^{\circ}29'$

Зургийг ашиглан даалгавруудыг гүйцэтгээрэй.

Монгол Улс нь “Атрын 3” хүртэл гурван удаагийн аяныг улсын хэмжээнд зохион байгуулсан нь улаан буудайн тариалалт нэмэгдэж гурилын үйлдвэрлэл өссөн. Гэтэл 2024 оны 5-р сарын нэгнээс улаан буудайг импортын татвараас чөлөөлөх шийдвэрийг гаргасан бөгөөд сүүлийн 5 жилд тариалалт 53 мянган тонноор буюу 20 гаруй хувиар, гурил үйлдвэрлэл 40 хувиар тус тус буурчээ.



10. Аж үйлдвэрлэлийн аль салбарын мэдээллийг илэрхийлсэн байна вэ?
 - A. хөнгөн үйлдвэр
 - B. олборлох үйлдвэр
 - C. эрчим хүчний үйлдвэр
 - D. хүнсний үйлдвэр
11. Гурилын үйлдвэрийн байршилд нөлөөлөх **эдийн засгийн** хүчин зүйл аль нь вэ?
 - A. түүхий эд
 - B. хөрсний бүтэц
 - C. уур амьсгал
 - D. ургах хугацаа
12. Улаан буудайн үйлдвэрлэлийн хамгийн эцсийн бүтээгдэхүүнийг сонгоорой.



13. Монгол улс 2024 оны байдлаар гурилын хэрэглээний хэдэн хувийг дотоодоосоо хангасан байгааг график ашиглан тооцоолж олоорой.
 - A. 69.8%
 - B. 56.7%
 - C. 39.6%
 - D. 30.2%
14. Гурилын үйлдвэрлэлийн хэмжээ сүүлийн 5 жилийн хугацаанд буурахад нөлөөлсөн хүчин зүйлийг сонгоорой.
 - A. хүмүүсийн гурилын хэрэглээ буурсан байдал
 - B. импортын албан татварыг чөлөөлсөн байдал
 - C. ажиллах хүний нөөц багассан байдал
 - D. техник технологи хуучирсан байдал
15. Гурил болон улаан буудайн импорт татваргүй хэвээр үргэлжилбэл газар тариалангийн салбарт тулгарч болзошгүй эрсдэлийг сонгоорой.
 - A. Хүнсний аюулгүй байдал: Олон улсын стандартын шаардлагад нийцээгүй гурил импортлогдож, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шаардлагыг хангахгүй.
 - B. Нийгмийн асуудлууд: Хот суурин газар нутгууд руу шилжилт хөдөлгөөн нэмэгдэж газар тариалангийн чиглэлээр бэлтгэгдсэн ажилчдыг сургах, ажлын байр олшрох.
 - C. Гадаад харилцаа: Олон улсаас импортоор бүтээгдэхүүн худалдан авах нь гадаад валютын урсгал нэмэгдэж эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх.
 - D. Салбарын хөгжил: Техник технологийн хэт хөгжил, чанартай бордоо ашиглах, тээвэр логистик бүхий аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадамжид нөлөөлөх.

16. Нэгэн сурагч УБ хот дахь “Cinema Next” кино театрт кино үзчихээд “Үндэсний соёл амралтын хүрээлэн” буюу хүүхдийн парк руу явахаар Google map ашиглан ямар автобусаар явахыг хайж үзэв. Аль чиглэлийн автобусыг сонговол хамгийн дөт очих боломжтой вэ?

A. 5:08 PM—5:48 PM 40 min
 > 4:40 > 4:32B > 4:17A >


B. 5:07 PM—5:53 PM 46 min
 > 4:37 > 4:63 >

C. 5:07 PM—5:55 PM 48 min
 > 4:50 >

D. 5:07 PM—5:55 PM 48 min
 > 4:64 > 4:17A >

17. Монгол Улсын уул уурхайн салбарын ДНБ-д үзүүлэх нөлөөг зурагт харуулав. Зургийг ашиглан оновчтой дүгнэлтийг сонгоорой.

МО-ны ДНБ-д үзүүлэх нөлөө (2020 он)



- A. Төмрийн хүдрийн салбар ашиг орлог өндөр, ДНБ-д хамгийн их хувь нэмэр оруулдаг.
 B. Зэс, алтны уул уурхайн томоохон ордууд эдийн засагт илүү их нөлөө үзүүлдэг.
 C. Уул уурхайн салбарын нөлөө улс орны эдийн засагт багахан хувийг эзэлдэг.
 D. Монгол орны эдийн засагт уул уурхайн салбарын орлого тал хүрэхгүй хувийг бүрдүүлдэг.

18. Улсын хэмжээнд 2025 оны эцэст, мал тооллогын урьдчилсан дүнгээр **58.1 сая** толгой мал тоологдлоо. Малын тоо өмнөх оноос 445.1 мянган толгойгоор буюу 0.8 хувиар өссөн байна. Малын тоог төрлөөр нь авч үзвэл:

- 🐄 Адуу 5.1 сая болж 9.5 хувиар өссөн,
 🐄 Үхэр 5.4 сая болж 7.2 хувиар өссөн,
 🐄 Тэмээ 501.3 мянга болж 4.3 хувиар өссөн,
 🐄 Хонь 23.9 сая болж 2.6 хувиар буурсан,
 🐄 Ямаа 23.2 сая болж 1.1 хувиар өссөн байна.


Хамгийн их хувийг ямар төрлийн мал хэдэн хувийг эзэлж байгааг зөв тодорхойлсон хувилбарыг сонгоорой.

- A. Тэмээ – 39.9% B. Хонь – 5.3% C. Хонь – 41.1% D. Тэмээ – 4.3%

19. Монголын аялал жуулчлалын хөгжлийг хамгийн сайн дэмжих хүчин зүйл аль нь вэ?

- A. Уул уурхайн олборлолтыг дэмжиж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
 B. Байгаль, соёлд суурилсан тогтвортой аяллыг нэмэгдүүлэх
 C. Хот байгуулалт, барилга байгууламжийг нэмэгдүүлэх
 D. Гадаад худалдаа буюу импортын барааг нэмэгдүүлэх

Зургийг ашиглан даалгавруудыг гүйцэтгээрэй.



20. Зургийг ажиглан хамгийн өндөр ердийн өсөлттэй байгаа нутгийг нэрлэж, хүн амын ердийн өсөлтийг хэрхэн тооцсоныг зөв тодорхойлсон хувилбарыг сонгоорой.

- Өмнөговь аймгийн Даланзадгад сум – хүн амын төрөлт их, нас баралт бага учир ердийн өсөлт хамгийн өндөр гарсан байна.
- Дорноговь аймгийн Сайншанд сум – хүн амын төрөлт их, нас баралт бага учир ердийн өсөлт хамгийн өндөр гарсан байна.
- Өмнөговь аймгийн Ханхонгор сум – хүн амын төрөлт бага, нас баралт их учир ердийн өсөлт өндөр гарсан байна.
- Дундговь аймгийн Сайнцагаан сум – хүн амын төрөлт бага, нас баралт ч бага учир ердийн өсөлт хамгийн өндөр гарсан байна.

21. Хүн амын ердийн өсөлт өндөр байхад нөлөөлсөн хүчин зүйлийг хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбон тайлбарласан хувилбарыг сонгоорой.

- Хүмүүсийн амьдралын чанар сайжирч, дундаж наслалт уртассанаар нас баралтын ерөнхий түвшин буурдаг.
- Хүн амын бүтцэд 15-64 насны хүмүүсийн эзлэх хувь өндөр байх нь төрөлтийн түвшнийг нэмэгдүүлдэг.
- Хүүхдийн мөнгө, эхийн одон, жирэмсний болон амаржсаны тэтгэмж зэрэг бодлогын дэмжлэгүүд нь төрөлтийг дэмжих хөшүүрэг болдог.
- Ажлын байрны нөөц өндөр учир хөдөлмөрийн насны хүн ам нь гэр бүлийн хамт ажил хийж амьжиргаагаа сайжруулах сонирхол их байдаг.

22. Хүн амын шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх татагч, түлхэгч хүчин зүйлсийн “Үнэн”, “Худал” байдлыг зөв тодорхойлсон хувилбарыг сонгоорой.

№	Тагтагч, түлхэгч хүчин зүйлс	Үнэн	Худал
1	Байгалийн гамшгаас үүдэн малын тоо толгой зүй бусаар хорогдох нь хүн амыг татах хүчин зүйл болно.		
2	Агаарын бохирдлоос болж эрүүл мэндийн асуудал үүсэх байдал нь хүн амын түлхэгч хүчин зүйл болно.		
3	ХАА-н үйлдвэрлэлийг дэмжиж орон нутгуудад хөгжүүлэлт хийх нь хүн амыг татах хүчин зүйл болно.		
4	Барилга байгууламжийн тоо жилээс жилд нэмэгдэж нягтшил өссөөр байгаа нь хүн амыг түлхэх хүчин зүйл болно.		
5	Соёл урлагийнхан орон нутгууд руу аялан тоглолтоор явах нь хүн амыг түлхэгч хүчин зүйл болно.		

A. 1-Ү, 2-Х, 3-Ү, 4-Х, 5-Ү


B. 1-Х, 2-Ү, 3-Ү, 4-Ү, 5-Х

C. 1-Ү, 2-Ү, 3-Х, 4-Ү, 5-Х

D. 1-Х, 2-Ү, 3-Ү, 4-Ү, 5-Ү

23. Дөрвөн малчин бүрийн эзэмшил бэлчээрийн талбайн хэмжээ болон маллаж буй малын тоо толгойг графикаар илэрхийлжээ.

Бэлчээрийн экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр, байгалийн эрсдэлийг давах хамгийн өндөр чадамжтай, тогтвортой мал аж ахуй эрхлэгч аль нь вэ?



A. **Малчин А:** Нийт 500 га талбай бүхий бэлчээрт 1000 толгой мал маллаж байгаа нь нэг га талбайд ногдох малын ачаалал стандартаас хоёр дахин хэтэрсэн хэдий ч бэлтгэсэн өвс тэжээлийг их хэмжээгээр хэрэглэх учир эдийн засагт эергээр нөлөөлж байна.

B. **Малчин Б:** Нийт 500 га бэлчээрийн талбайд 400 толгой мал ногдож байгаа нь ургамлын нөмрөг нөхөн сэргэх боломжийг бүрэн хангаж, бэлчээрийн даацад нийцсэн тул ган зуд зэрэг цаг агаарын хүндрэлийг хохирол багатай давах нөөц боломжтой байна.

C. **Малчин В:** Нийт 200 га бэлчээрийн талбайтай боловч 600 толгой мал маллаж байгаа нь бага талбайг ашиглаж байгаа ч малын тоо толгой олон учир ашиг шимийн гарц их, өрхийн ашиг орлого хангалттай байх боломжтой байна.

D. **Малчин Г:** Нийт 100 га талбайд 300 толгой мал маллаж байгаа нь маш бага хэмжээний талбайд мал аж ахуй эрхэлж байгаа учир бэлчээрийн даацад нөлөөлөхгүйгээр малын ашиг шимээ нэмэгдүүлэх боломжтой байна.

24. Дархан-1 өртөөнөөс Шарын гол хүртэл №601 дугаар галт тэрэг 64 км урттай төмөр замаар өдөрт ирж, буцах 2 удаагийн тээвэрлэлт хийдэг. Ингэхдээ өдөрт дунджаар 150 зорчигч тээвэрлэдэг тооцоо гарчээ. Нэг өдрийн зорчигч эргэлт хэд байх вэ?

($Z=H \cdot S$, Z - зорчигч эргэлт, H -нийт зорчсон хүний тоо, S -нийт явсан зам


A. 4800 хүн/км

B. 9600 хүн/км

C. 38400 хүн/км

D. 19200 хүн/км

25. Зургийг ашиглан хүснэгт дэх асуулт бүрийн хариултыг хамгийн оновчтой тодорхойлсон хувилбарыг сонгоорой.



- i. Зураг дээрх өдөр, шөнийн зааг яагаад шулуун бус "S" хэлбэрийн муруй шугамаар харагдаж байна вэ?
 - A. Дэлхий тэнхлэгээ тойрон эргэх хурд өөр өөр байдаг учир
 - B. Дэлхий нарыг тойрох хөдөлгөөний үр дүнд нарны тусгал өргөрөг бүрд харилцан адилгүй тусдаг учир
 - C. Дэлхийн гадаргуугийн өндөр намын зөрүү болон уул нуруудын сүүдэр туссан учир
 - D. Сарны татах хүчний нөлөөгөөр агаар мандалд гэрлийн хугарал үүссэн учир
- ii. Зураг дээрх нарны тэмдэглэгээ байрлаж байгаа хэсгийг ажиглан тохирох тодорхойлолтыг сонгоорой.
 - A. Тухайн бүс нутагт зун болж байгааг илэрхийлж байна.
 - B. Нар тухайн цэг дээр эгц дээрээс буюу 90° -ийн өнцгөөр тусаж байна.
 - C. Нар тухайн бүс нутагт жаргаж байгааг илэрхийлж байна.
 - D. Тухайн цэгт сарны хиртэлт болох гэж байгааг илэрхийлж байна.
- iii. Улаанбаатар хоттой аль дүгнэлт нь хамааралтай вэ?
 - A. Улаанбаатарт өглөөний 03:44 цаг болж байгаа тул шөнө байна.
 - B. Улаанбаатар хот цагаан хэсэгт байгаа бөгөөд зуны туйлын өдөр болж байна.
 - C. Улаанбаатар хот бүрэнхий бүсэд байгаа тул нар жаргаж байна.
 - D. Улаанбаатарт өвлийн улирал эхэлж байгаа тул хамгийн богино өдөр тохиож байна.